ЗАХИАЛАГЧ:

НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭГЧ:

ЭС АР ПИ ИНЖЕНЕР КОНСАЛТИНГ МОНГОЛИА ХХК

03/21

Тайлбар бичиг

"СҮНЖИН ГРАНДААС ГЭР ХОРООЛОЛ ДУНДУУР НАРНЫ ЗАМ ХҮРТЭЛХ ГУДАМЖ, ЗАМ (БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 13 ДҮГЭЭР ХОРОО)-ЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ" ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ

Захирал **Г.УУГАНБАЯР**

Инженер **Ё.ЭНХБАТ**

ЭС АР ПИ ИНЖЕНЕР КОНСАЛТИНГ МОНГОЛИА ХХК
ENGINEER CONSULTING MONGOLIA Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ

Зураг төсл ... янасан
ЭКСПЕРТ № .....
... арын үсэг/
... сар ... өдөр
Засвартай
эс ...
2022.02.16.
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

УЛААНБААТАР ХОТ 2021 ОН

БҮЛЭГ 1: ЕРӨНХИЙ ЗҮЙЛ 3
1.1 ҮНДЭСЛЭЛ 3
1.2 АЖЛЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН 3
1.3 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА 3
БҮЛЭГ 2: ТРАССЫН СУДАЛГАА....4
2.1 ТӨЛӨВЛӨЖ БУЙ АВТО ЗАМЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ 4
БҮЛЭГ 3: АВТО ЗАМ ТӨСӨЛЛӨЛТ....11
3.1 ЗАМЫН АНГИЛАЛ, ТӨСӨЛЛӨЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД....11
3.2 ТРАСС ТӨЛӨВЛӨЛТ....13
3.3 ЗАМЫН ТРАСС БА ДЭВСГЭР ЗУРАГ....15
3.4 ХУЧИЛТЫН ТООЦОО 17
3.5 ХУЧИЛТЫН ХИЙЦ БОЛОН ХӨНДЛӨН ОГТЛОЛ....19
БҮЛЭГ 4: АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ, ТӨСӨВ 22
БҮЛЭГ 5: УС ЗАЙЛУУЛАЛТ 22
5.1 Зорчих хэсгийн борооны ус зайлуулах шугам сүлжээний тооцоо, төсөллөлт....22
БҮЛЭГ 6: ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ....27
БҮЛЭГ 7: ГАРЦ УУЛЗВАР 27
БҮЛЭГ 8: ЗАМЫН ТОНОГЛОЛ 27
БҮЛЭГ 9: АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ 34
9.1 Танилцуулга....34
9.2 Барилгын бэлтгэл ажил....34
9.3 Төслийн хэрэгжилт буюу зам барилгын ажил 34
9.4 Барилгын ажлын төлөвлөгөө 35
БҮЛЭГ 10: ЗАСВАР АРЧЛАЛТ....36
10.1 Ерөнхий....36
10.2 Асфальтобетон хучилттай замын засвар арчлалт 36
10.3 Ус зайлуулах байгууламжийн засвар 36
БҮЛЭГ 11: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ....37
БҮЛЭГ 12: ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ....37
БҮЛЭГ 13: САНАМЖ 38

БҮЛЭГ 1: ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 сарын 30-ны өдрийн А/523 тоот захирамж, ЗД-БЗД/2021/015 дугаартай Сүнжин Грандаас урагш гэр хороолол дундуур нарны зам хүртэлх авто замын зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу 2021 оны 08 дугаар сард хийгдсэн геодези, инженер геологийн хэмжилт судалгааны материалд тулгуурлан тус замын зураг төслийг боловсруулав.

1.1 ҮНДЭСЛЭЛ

- Нийслэлийн Засаг даргын захирамж, зураг төсөл боловсруулах зургийн даалгавар
- “5D WORLD” ХХК-ийн хийсэн 1:500-ны масштабтай байр зүйн зураглалын ажил
- “Монгео эко тех” ХХК-ийн хийсэн инженер-геологийн судалгааны материал
- Авто зам төсөллөх ЗЗБНбД 22-004-2016
- Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт БНбД 30-01-04
- Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596-2014
- Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597 : 2013
- Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 4759 : 2013
- Авто замын байгууламж, гудамж, замын гадаргуугийн ус зайлуулах сувгийн U хэлбэрийн төмөрбетон бүтээгдэхүүний бүтээц нэр төрөл ба хэмжээ MNS 6494-2014
- Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль БД31-101-04
- Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНбД 32-02-12
- Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага MNS 6808:2019
- Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН 2.01.01-2004
- Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗХТ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэнэ.

1.2 АЖЛЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

- Боть-1 Авто зам, замын байгууламжийн ажлын зураг төсөл
- Боть-2 Тайлбар бичиг
- Боть-3 Техникийн шаардлага
- Боть-4 Геологийн хайгуул судалгааны материал, инженер-геологийн тайлан
- Боть-5 Геодезийн 1:500-ны масштабтай байр зүйн зураг, ажлын тайлан
- Боть-6 Цахилгаан, гэрэлтүүлэг зураг тайлан
- Боть-7 Хот байгуулалт, хөгжлийн газрын ерөнхий төлөвлөгөөний загвар зураг
- Боть-8 Дулаан шугам хүчитгэх зураг төсөл, төсөв

1.3 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

- **Төслийн захиалагч байгууллага:** Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
- **Төслийн нэр:** УБ хот, БЗД, 13-р хороо Сүнжин Грандаас урагш гэр хороолол дундуур нарны зам хүртэлх авто замын ажлын зураг төсөл боловсруулах
- **Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:** Нийслэлийн төсвийн хөрөнгө
- **Авто замын техникийн ангилал, замын зэрэг:** Туслах гудамж зам

- **Замын хучилтын хийц:** Хучилтын бүтээцийн тооцоогоор үндэслэнэ
- **Зураг төсөл зохиох үе шат, хугацаа:** 1 үе шаттай 2021 он
- **Зураг төслийн байгууллага:** “Эс Ар Пи Инженер Консалтиг Монголиа” ХХК (Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага)
- **Зургийн инженер:** Ё.Энхбат
- **Зураг төслийг боловсруулахад оролцсон туслан гүйцэтгэгч байгууллагууд:**
  - Геодезийн хэмжилт боловсруулалт, зураг төсөл, сургалт үйлчилгээний “5D World” ХХК
  - Барилгын инженер-геологийн “ Талын хөрс” ХХК
- **Байршил:** Баянзүрх дүүрэг, 13-р хороо



Зураг 1.3.1 Байршлын схем

БҮЛЭГ 2: ТРАССЫН СУДАЛГАА

2.1 ТӨЛӨВЛӨЖ БУЙ АВТО ЗАМЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Одоо байгаа авто замын нөхцөл байдлын судалгааны ажлын хүрээнд дараах ажлыг хийсэн.

Талбайн хайгуул байр зүйн судалгаа:

2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр НАЗГ-ын ЗД-БЗД/2021/015 дугаартай авто замын зураг төсөл боловсруулах даалгаварт өгсөн трассын тэнхлэгийн дагууд талбайн хайгуул судалгаа хийсэн. Замын эхлэл, эргэлтийн өнцөг, замын төгсгөл зэрэг онцлог цэгийн байршлыг газар дээр нь бодитоор шалган туслан гүйцэтгэгч байгууллагын ажлыг эхлүүлсэн.

Төлөвлөж буй замын трассын дагуу хийсэн судалгааны фото зургийг дараах хэсгээс үзнэ үү.

Зураг 2.1.1 Төлөвлөж буй авто замын өнөөгийн байдал (Хавсралт 1)

Тайлбар:

1– Трассын эхлэл /Нарны замтай уулзах хэсэг/

2– Трассын дунд хэсэг

3– Үерийн суваг

4– Трассын төгсгөл хэсэг

Зураг 2.1.2 Төлөвлөж буй авто замын өнөөгийн байдал

Зураг 2.1.3 Төлөвлөж буй замын өнөөгийн байдал

Зураг 2.1.4 Төлөвлөж буй замын өнөөгийн байдал

- Трассын эхлэл хэсэг /Нарны замтай уулзах хэсэг/

Зураг 2.1.5 Нарны замтай уулзах хэсэг /Зүүн талаас харагдах байдал/

Зураг 2.1.6 Нарны замтай уулзах хэсэг /Хойд талаас харагдах байдал/

Зураг 2.1.7 Баруун талаараа Орчлон хүнсний дэлгүүр, зүүн талаараа үерийн сувгаар хашигдсан хэсэг

Зураг 2.1.8 Үерийн суваг нарны замд нийлэх хэсэг

- Трассын дунд хэсэг

Зураг 2.1.9 Орчлон дэлгүүрийн ар тал

Зураг 2.1.10 Баруун талаараа бетон хашаа, зүүн талаарааа үерийн далангаар хашигдсан хэсэг

Зураг 2.1.11 Трассын дунд хэсэг

Зураг 2.1.12 Трассын дунд хэсэг

Зураг 2.1.13 Трассын дунд хэсэг

Зураг 2.1.14 Трассын дунд хэсэг

- Үерийн суваг

Зураг 2.1.15 Трассын эхлэл-Үерийн суваг Үерийн суваг дээрх явган хүний гарц №1

Зураг 2.1.16 Трассын эхлэл-Үерийн суваг

Зураг 2.1.17 Трассын дунд-Явган хүний гарцтай хэсэг

Зураг 2.1.18 Трассын дунд-Үерийн суваг Үерийн суваг дээрх явган хүний гарц №2

- Трассын төгсгөл хэсэг

Зураг 2.1.19 Трассын төгсгөл хэсэг /холоос/

Зураг 2.1.20 Трассын төгсгөл хэсэг /ойроос/

Зураг 2.1.21 Трассын төгсгөл /хойд талаас/

Зураг 2.1.22 Трассын төгсгөл /хойд талаас/

Зураг 2.1.23 Трассад өртөж буй дулааны шугам сүлжээ

БҮЛЭГ 3: АВТО ЗАМ ТӨСӨЛЛӨЛТ

3.1 ЗАМЫН АНГИЛАЛ, ТӨСӨЛЛӨЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Авто замын техникийн ангилал, зэрэг нь “Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам” буюу “Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-004-2016 стандартын дагуу хуримтлуулагч зам – 2Б байна.

Хуримтлуулагч, тусгай зориулалтын зам – 2Б

Хуримтлуулагч, тусгай зориулалтын замын хувьд хөдөлгөөний эрчим багатай боловч ачааны болон амралт, аялал жуучлалаар яваа тээврийн хэрэгсэл харьцангуй их зорчдог, аялал жуучлал болон байгалийн цогцолбор газрууд, уул уурхай, үйлдвэр, хөдөө аж ахуйн бүс рүү болон ачаа тээврийн терминал хүрэх замыг тодорхойлох учир, зэрэглэл 2Б зам дараах шалгууруудын аль нэгийг хангасан байх

1. **Хүн ам** – 500-аас дээш хүн амтай суурин, тосгоны болон жуулчдын зорих хэрэгцээг хангах.
2. **Хөдөлгөөний эрчим** – Замаар өнгөрөх тээврийн хэрэгслийн 75-аас дээш хувийг хүнд даацын болон урт, овор хэмжээний ачааны тэрэг эзлэх, хоногийн хөдөлгөөний дундаж эрчим өөр зэрэглэлийн замуудын эрчмийг оруулахгүйгээр 100-аас дээш байх.
3. **Сүлжээний үргэлжлэх байдал** – Дээр өгүүлсэн шалгуур үзүүлэлтийг хангахын зэрэгцээ 2А зэрэглэлийн замын сүлжээний сегмент хоорондын сүлжээнд үүсэх тасалдлыг бууруулах. Энэ төрлийн замууд тусгай зориулалтын хөдөлгөөнийг (ачаа тээврийн терминал, уул уурхай, үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газар, суурин, зоогийн газар зэрэгт хүрэх) цуглуулж байгаа бол замын төгсгөлд мухар замтай холбож болно.
4. **Тусгай зориулалтыг хангах** – Тусгай зориулалтын замын хувьд хийтийн тээвэр явдаггүй, уул уурхайн бүтээгдэхүүн, газрын тос, хүнд үйлдвэрийн материал, бүтээгдэхүүн болон бусад ачааг тээвэрлэхэд зориулсан, 1 тэнхлэг дээрээ 11.5 тн-оос дээш ачаалалтай, тусгай хүнд даацын тээврийн хэрэгсэл явахад зориулагдана.

Хүснэгт 5.1.1 Тусгай зориулалтын хуримтлуулагч замын тооцоот хурд

Үндэслэл	Замын ангилал	Замын зэрэглэл	Замын нэршил	Замын тооцоот хурд, км/цаг		
				Тал газар	Нугачаатай газар	Уулархаг газар
“Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-004-2016	Хуримтлуулагч зам	2Б	Тусгай зориулалтын хуримтлуулагч зам	60	50	30

Хүснэгт 5.1.2 Хөдөлгөөний зурвас болон замын өргөн

Замын ангилал	Хөдөлгөөний зурвасын тоо	Зурвасын өргөн,м	Зорчих хэсгийн өргөн,м	Явган замын өргөн, м	Уулзвар руу ойртож байгаа хэсэгт	Тайлбар
Хуримтлуулагч зам	2	3.0-3.6	6.0-7.2	≥1.2	6.5	

Хүснэгт 5.1.3 Үзэгдэлтийн зай

Тооцоот хурд км/ц	Зогсох үеийн үзэгдэлтийн зай, м	Гүйцэж түрүүлэх үеийн үзэгдэлтийн зай, м
50	65	160

Хүснэгт 5.1.4 Хамгийн их дагуу налуу

Гадаргуугийн төрөл	2Б		
	Тооцоот хурднаас хамаарсан хамгийн их дагуу налуу %		
	Төсөллөлтийн тооцоот хурд, км/ц		
	30	50	60
Тэгш	9	9	9
Нугачаатай	12	11	10
Уулархаг	12	12	12

Хүснэгт 5.1.5 Хэвтээ муруйн хамгийн бага радиус

Тооцоот хурд, км/цаг	Хучилтын авцалдалтын илтгэлцүүр	Хамгийн бага радиус, м		
		Эргэцийн хамгийн их налуу		
		4%	6%	8%
50	0.19	86	79	73

Хүснэгт 5.1.6 Босоо хотгор муруйн хамгийн бага хэмжээ

Тооцоот хурд	Тооцсон хурд	Зогсох үеийн хамгийн бага үзэгдэх зай	Хотгор муруйн хамгийн бага К утга	
			Гэрлийн хяналт	Таю тухын хяналт
50	50	65	12	7

Хүснэгт 5.1.7 Босоо гүдгэр муруйн хамгийн бага хэмжээ

Тооцоот хурд	Тооцсон хурд	Гүдгэр муруйн хамгийн бага үзэгдэх зай	Гүдгэр муруйн хамгийн бага К утга	
			ЗҮҮЗ	ГТҮЗ
50	50	340	10	125

3.2 ТРАСС ТӨЛӨВЛӨЛТ

Зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу Зураг 5.2.1 үзүүлснээр трасс төлөвлөхөөр трассын төгсгөл хэсгийг одоо байгаа замтай холбож уялдуулах шаардлагатай гэж үзэн Зураг 5.2.2-д үзүүлснээр төлөвлөв.

Зураг 5.2.1 Зураг төсөл боловсруулах даалгавар (Хавсралт 2)

Зураг 5.2.2 Трасс төлөвлөлт (Хавсралт 3)

Сүнжин Грандаас гэр хороолол дундуур нарны зам хүртэлх авто замын зураг төслийг батлагдсан ажлын даалгаврын замын ангилал, замын бүрэлдэхүүн хэсгүүдийн төлөвлөлт, хэвтээ төлөвлөлт, босоо төлөвлөлт зэрэг замын техникийн үзүүлэлтүүдийг “Авто зам төсөллөх” ЗЗБНбД-ийг мөрдлөг болгон төлөвлөсөн болно.

Объектын нэр: *СҮНЖИН ГРАНДААС ГЭР ХОРООЛОЛ ДУНДУУР НАРНЫ ЗАМ ХҮРТЭЛХ ГУДАМЖ, ЗАМ (БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 13 ДҮГЭЭР ХОРОО)-ЫН ЗУРАГ ТӨСӨЛ* *Шифр: 03/21 Төсөв ЗТ 03/21*					
Зураг төслийн гүйцэтгэгчийн нэр тусгай зөвшөөрлийн дугаар		“Эс Ар Пи инженер консалинг Монголия ” ХХК			
Хөрөнгө оруулагч / захиалагч / байгууллагын нэр, хөрөнгө оруулалтын хэмжээ, сая / төг		НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР			
Байршлын байгаль, цаг уурын нөхцөл		Эрс тэс			
[1]	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хэмжээ		
			TPACC-1	TPACC-2	Явган хүний зам
1	Замын зэрэг	-	Туслах гудамж зам		
2	Замын урт	м	509.77	245.12	144.90
3	Тойруугийн тоо	ш	8	4	2
4	Тойруугийн хамгийн бага радиус	м	250	50	150
5	Тойруугийн хамгийн их радиус	м	600	250	150
6	Тойруугийн нийт урт	м	218.45	49.33	48.68
7	Тойруугийн трассад эзлэх хувь	%	42.8 %	20.12 %	33.60 %
8	Дагуугийн хамгийн их налуу	%	0.16 %	0.31 %	0.12%
9	Дагуугийн хамгийн их налуугийн үргэлжлэх урт	м	11.63	10.37	47.2
10	Зорчих хэсгийн өргөн	м	1.5*2 ; 3.0*2	1.5*2	

11	Явган хүний замын өргөн	м	1.5	1.5	1.0*2
12	Хөвөөний өргөн	м	0.5	0.5	0.5
13	Өндөрлөгөөний хажуу налуу	m:n	1:1.5	1:1.5	1:1.5
15	Ухмалын хажуу налуу	m:n	1:1.5	1:1.5	1:1.5
16	Хучлагын төрөл	-	Хатуу бус хучилт		
18	Хучилтын хийц	-	Өнгө АБ хучлага 3 см Суурь АБ хучлаг 4 см Буталсан чулуун суурь 20 см Хөлдөлтөөс хамгаалах үе 30 см		Явган замын хавтан 6 см Цементээр бэхжүүлсэн элс хайрган хуурай хольц 3см Буталсан чулуун суурь 10 см

3.3 ЗАМЫН ТРАСС БА ДЭВСГЭР ЗУРАГ

Сүнжин грандаас гэр хороолол дундуур нарны зам хүртэлх гудамж зам хүртэлх авто замын геодезийн хэмжилт, геологийн дүгнэлт болон зургийн даалгаврыг үндэслэн замын зураг төслийн норм, дүрмийн дагуу боловсруулан цаашид хийгдэх зам барилгын ажлын тоо хэмжээг гарган төсөвт өртөгийг тооцсон.

Тус замыг төлөвлөхдөө зургийн даалгаварт өгсөн замын ерөнхий төлөвлөлтийг үндэслэн, замын зурвас газрын гадаргын байдал, цахилгаан, шугам сүлжээ болон эзэмшил газар зэргийг харгалзан тусган Нарны замаас эхлэн Сүнжин гранд хүртэл үргэлжилнэ.

Замын зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт Замын техникийн ангилал, замын зэргийг “ Туслах гудамж зам ” гэж өгсөн. Иймд 2016 онд шинээр батлагдсан ЗЗБНбД 22-004-2016 дугаартай “Авто зам төсөллөх”-ийн 10.3-т заасан “Хотын хуримтлуулагч гудамж зам” ангиллаар төсөллөсөн.

1. **Трасс - 1** 0+000.000 - 0+234.333 хүртэл 1 эгнээ 3.0м өргөнтэй, 0+260.298 - 0+509.772 хүртэл 2 эгнээ 6м өргөнтэй.

2. **Трасс - 2** 0+020.000 - 0+050.000 хүртэл 1 урсгалд 1 эгнээ 8м өргөнтэй, 0+050.000 - 0+245.118 хүртэл 1 эгнээ 3.0м өргөнтэй

3. **Явган хүний зам** 0+006.340 – 0+144.898 1 эгнээ 2м өргөнтэй байхаар төсөллөсөн.

Трасс-2-ын 0+230.000-д авто машин буцаж эргэх нөхцлийг бүрдүүлж U хэлбэрийн эргэлт төсөллөсөн бөгөөд “Авто зам төсөллөх” 22-004-2016 норм, дүрмийн бүлэг1 “Авто замын ангилал ба төсөллөлтийн үндсэн зарчим”-д заасан Хавсралт1, Хүснэгт 2 “Тооцоот тээврийн хэрэгслийн хамгийн бага эргэх радиус”-ын хотын доторх энгийн сургуулийн автобус машиныг сонгосон. Мөн “A police on Gemetric Design of Highway and Streets” норм дүрмийн Location and Design of U-turn

median opening хэсэгт заасан шаардлагын дагуу авто замын мөрийг IndorCAD программаар шалгасан.



Зураг 5.3.1 Хотын доторх энгийн сургуулийн автобус машин буюу S-BUS11 тээврийн хэрэгсэл



Зураг 5.3.2 Сургуулийн уламжлалт автобусны (S-BUS-11) хамгийн бага эргэлтийн зам



Зураг 5.3.3 Трасс1 ПК0+520-д байрлах эргэлттэй хэсэг:

Дэвсгэр зургаас харахад цахилгаан, мэдээлэл холбооны болон ус, дулааны шугам байгаа учир зам барилгын ажил эхлэхээс өмнө зохих байгууллагаас инженер байлцуулан шаардлагатай арга хэмжээг авна.

Замын трасстай огтлолцож байгаа цэвэр, бохир усны шугам сүлжээг холбогдох байгууллагын техникийн нөхцлийн дагуу хүчитгэх зургийг төсөллөж, замын зурагт хавсаргав.

Төлөвлөж буй авто замын 2 талаар байрлаж буй албан байгууллагын орц, гарцыг төсөллөсөн.

3.4 ХУЧИЛТЫН ТООЦОО

Авто замын хучилтын хийцийг төсөллөхдөө Авто зам төсөллөх ЗЗБНбД 22-004-2016 норм ба дүрмийн 15 дугаар бүлэгт заасны дагуу ОХУ-ын “Отраспевые дорожные нормы проектирование нежестих дорожных одежд” ОДН 2018.046-01-ын аргачлалаар IndorPavement программ хангамж ашиглаж тооцоог гүйцэтгэсэн болно.

Мөн хавсралт хэсэгт програмаас авсан эх тайланг орос хэл дээр байгаа байдлаар үзүүлэв.

Тооцоогоор төлөвлөсөн хучилтын бүтээц:

- Өнгө асфальтбетон хучилт – 3см
- Суурь асфальтбетон хучилт – 4см
- Буталсан чулуун суурь – 20см
- Хөлдөлтөөс хамгаалах үе – 30см

1. Өгөгдөл

- Төслийн нэр: Сүнжин Грандаас урагш гэр хороолол дундуур нарны зам хүртэлх авто зам
- Төсөл хэрэгжих бүс нутаг: УБ хот, БЗД, 13 дугаар хороо
- Хийгдэх тооцоонууд:
  1. Уян харимхайн хотойлт
  2. Гулсалт
  3. Статистик ачаалал

4. Хүйтэн тэсвэрлэлт
5. Дугуйн мөрний хотойлтын шалгалт

- Зам – цаг уурын бүсчлэл: II-В
- Чийгшилтийн төрөл: 1-р схем /атмосферын хур тунадас/
- Хөрсний тооцоот чийгшил, Wp: 0.59
- Хөрсний нягтралын коэффициент : 1.00
- Хөлдөлтийн гүн, м: 3.50
- Дагуу налуу, промиль: 20.0

Төсөллөлтийн өгөгдөл:

- Техникийн ангилал: 2Б /Нэг болон хоёр эгнээ зам/
- Хучилтын төрөл: Капитал
- Тогтоосон найдваржилт Кн: 0.95
- Ашиглалтын тооцоот хугацаа Тсл, жил: 15
- Зорчих хэсгийн өргөн м: 7.0

Тооцоот ачаалал:

- Дугуйн дахь даралт *p* МПа: 0.80
- Дугуйн мөрний диаметр *D* (дин) см: 34.00
- Хөдөлгөөнгүй дугуйн штампын диаметр см: 30.00
- Тэнхлэг дээрх статистик ачаалал Q, кН: 115.00

Ачаалал үйлчлэх нийлбэр тоо

- Ачаалал үйлчлэх нийлбэр тоо: 375 000

2. Хучилын хийцийн тооцооны үр дүн:



Хучилтын хийц тооцоогоор:

H_1= 3см Өнгө асфальтбетон хучилт

H_1= 4см Суурь асфальтбетон хучилт

H_1= 20см Буталсан чулуун суурь

H_1= 30см Хөлдөлтөөс хамгаалах үе



3. Дүгнэлт

1. Энэхүү авто замын хучилтын хийц нь
    1) Уян харимхайн хотойлт /бат бөх/
    2) Гулсалтын эсэргүүцэл
    3) Статистик ачааллын үйлчлэлийн бат бөх
    4) Хүйтэн тэсвэрлэлт
    5) Дугуйн мөрний ховил

Дээрх **5** шалгуур үзүүлэлтээр тооцооны дүн хангалттай гарлаа.

IndorPavement програмаас гарсан тооцоог хавсралт 2-оос үзнэ үү.

3.5 ХУЧИЛТЫН ХИЙЦ БОЛОН ХӨНДЛӨН ОГТЛОЛ

- **Трасс - 1** 0+000.000 - 0+234.333 хүртэл 1 эгнээ 3.0м өргөнтэй, 0+260.298 - 0+509.772 хүртэл 2 эгнээ 6м өргөнтэй.
- **Трасс - 2** 0+020.000 - 0+050.000 хүртэл 1 урсгалд 1 эгнээ 8м өргөнтэй, 0+050.000 - 0+245.118 хүртэл 1 эгнээ 3.0м өргөнтэй
- **Явган хүний зам** 0+006.340 – 0+144.898 1 эгнээ 2м өргөнтэй байхаар төсөллөсөн.

Хөвөө 0.5м байх ба хучилтын хийцийг холбож байгаа замуудын хучилттай ижил байхаар асфальтбетон хучлага төсөллөсөн.

Тухайн авто замын хувьд:

	Үе	Зузаан /мм/
1	Өнгө асфальтбетон хучлага	3 см
2	Суурь асфальтбетон хучлага	4 см
3	Буталсан чулуун суурь	20 см
4	Хөлдөлтөөс хамгаалах үе	30 см

Трасс - 1 0+000.000 - 0+234.333



Трасс - 1: Ногоон байгууламжтай хэсэг



Трасс – 1: Явган хүний замтай хэсэг



БҮЛЭГ 4: АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ, ТӨСӨВ

Газар шорооны ажил, хучлагын ажлын хэмжээг Авто замын төлөвлөлтийн “IndorCAD/Road - 2019” программаар тооцоолсон. Зам барилгын ажлын хяналтын төсвийг “RBC-Estimator”программ ашиглан хийв.

Ус сувгийн удирдах газар:

1. Трассад орсон бохир усны худгийг бетон хийцээр өндөрлөж тааруулах.
2. Зориулалтын даацын люк таг тавих

Трассыг төлөвлөхдөө эдгээр ажлуудыг үндэслэн дагуу огтлолыг төлөвлөсөн ба төсөвт тооцсон.

“Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨК:

1. Замын трассад орсон худгийн таг хүзүүг тааруулж хүчитгэн шинээр суурилуулна.
2. Замын трассад орсон агаарын баганыг замын трассын гадна шилжүүлэн суурьшуулж кабелыг шинээр татна.
3. Сувагчлалыг гэмтээхгүй хамгаалах арга хэмжээ авч газар шорооны ажлыг гараар гүйцэтгэнэ.

Ажилбаруудын зардлыг тооцож нийт төсөвтд суулгасан болно.

Цахилгааны шугам:

Гэрэлтүүлэг суулгах, цахилгааны шон шилжүүлэх ажлын зураг, төсвийг “ЭЛСТА” ХХК боловсруулж, төсөвт тооцсон.

Дулааны шугам:

Дулааны шугам хүчитгэх ажлын зураг төсөл, төсвийг “МӨНГӨН БАЛЫШ” ХХК боловсруулж, төсөвт тооцсон.

Үерийн сувгийн дээрхи явган хүний гарцыг засварлах ажлын хүрээнд явган замын хайсыг зэврэлтээс хамгаалах сайн чанарын органик бус, цайраар баялаг будгаар будна. Зам барилгын ажлын үед тухайн явган хүний гарц эвдрэл ихтэй байвал магадлашгүй ажлын зардлаас тооцож урсгал засвар хийнэ.

БҮЛЭГ 5: УС ЗАЙЛУУЛАЛТ

Авто замын гадаргуугийн усыг L хэлбэрийн авто замын хашлага лоткигоор одоо байгаа үерийн усны суваг руу зайлуулахаар төлөвлөсөн. (Зураг 6.3.1)

Нүхтэй L хэлбэрийн авто замын хашлага болон лоткиг төлөвлөж буй замын дагуу нэг талд нь 20м тутамд байрлуулна.

Замын зорчих хэсгийн хөндлөн хэвгий нэг талруугаа 2% байх ба зорчих хэсэг рүүгээ явган зам 2%, ногоон байгууламж 2%, хөвөө 4% хэвгийтэй байхаар төлөвлөсөн. (Зураг 6.3.1)

5.1 Зорчих хэсгийн борооны ус зайлуулах шугам сүлжээний тооцоо, төсөллөлт

Нэг. Авто замын байршил, ус зайлуулах шугам сүлжээний төлөвлөлт

Шинээр төлөвлөж буй гудамж зам нь Сүнжин Грандаас урагш гэр хороолол дундуур нарны зам хүртэл 510м урт үргэлжилнэ. Газрын гадаргуун ерөнхий хэвгий хойноос Сэлбэ гол болон Туул гол руу урагш налуутай байна.

Төсөллөж буй гудамж замын орчны тойм зургийг доор Зураг 1-ээс үзнэ үү. Зурагт ус хураах талбайг тэмдэглэв. Тус зам нь үерийн сувгийн дагуу төлөвлөгдөж байгаа бөгөөд үерийн сувгийн баруун талын ус хураах талбайг (S1) ягаан өнгөөр, зүүн талын ус хураах талбайг (S2) цэнхэр өнгөөр ялгаж үзүүлэв.

Тус зам нь хойд талаараа Энхтайваны өргөн чөлөө буюу 6 эгнээ авто зам, оффицерийн тойргоор, баруун болон зүүн талаараа үерийн сувгаар, урд талаараа нарны замаар хашигдана.

Зураг 7.1.1. Төсөллөж буй замын байршил ба ус хураах талбай

Тайлбар

- *Замын урт - 0.51 км*
- *S_1 / Үерийн сувгийн баруун хэсэг / - 0.199 км2*
- *S_2 / Үерийн сувгийн зүүн хэсэг / - 0.123 км2*
- *Газрын гадаргуугаар ус урсах чиглэл*
- *Үерийн сувгаар ус урсах чиглэл*
- *Одоо байгаа авто замын борооны ус зайлуулах U суваг*

Төлөвлөж буй замын дагууд байрлах үерийн суваг руу /Зураг 2-г үзэх/ зорчих хэсгийн гадаргуугийн усыг U сувгаар зайлуулах зохистой байна. Ашиглалтын явцад цэвэрлэгээ хийхэд тагтай U суваг нь илүү тохиромжтой.



Зураг 7.1.2. Үерийн суваг

Хоёр. Гудамж замын зорчих хэсгийн сувгийн тооцоо

Ус зайлуулах шугам сүлжээний тооцоот зарцуулгыг тодорхойльё. Тооцоог хүснэгтлэн хийв. Хүснэгт 1-г үзнэ үү.

Хүснэгт 1. Тооцоот зарцуулгын тооцоо

№	Талбай, га	q20, л/с	n	A	Zmid	Tr, мин	Qr, л/с	β	Q cal, л/с
1	19.9	50	0.41	170.76	0.064	7.63	274.13	0.8	219.30
2	12.3	50	0.41	170.76	0.064	7.18	173.57	0.8	138.86

Доор тооцоонд хэрэглэгдсэн үндсэн томьёонуудыг оруулав. Үүнд:

a. Борооны усны тооцоот зарцуулга, л/с

$$q_r = \frac{z_{mid} A^{1,2} F}{t_r^{1,2n-0,1}},$$

b. Параметр А ба П

$$A = q_{20} \cdot 20^n \left(1 + \frac{\lg P}{\lg m_r}\right)^{\gamma},$$

c. Борооны ус урсах тооцоот хугацаа

$$t_r = t_{con} + t_{can} + t_p ,$$

d. Борооны ус зайлуулах шугам сүлжээний тооцоот зарцуулга

$$q_{cal} = \beta q_r ,$$

Гурав. Ус зайлуулах ил шугамын нүхний хэмжээг тогтоох

U бетон суваг зорчих хэсгийн 1 талаар хийх

1. Үерийн сувгийн баруун талын ус хураах нийт талбай 219.30 л/с буюу 0.22 м3/с байна.
2. Үерийн сувгийн зүүн талын ус хураах нийт талбай 138.86 л/с буюу 0.14 м3/с байна.

Иймд бетон U сувгийн стандартаас гидравликийн тооцоог үндэслэн төрлийг сонгов. Тус төсөллөлтийн хувьд 400 С төрлийн бетон суваг сонгож болж байна.

Хүснэгт 2-г үзнэ үү.

Хүснэгт 2. Сувгийн төрөл, зай хэмжээ, техникийн үзүүлэлтүүд

Сувгийн төрөл	Зай хэмжээ	Урсгалын хөндлөн огтлолын талбай-A, м2	Нойтон периметр-P, м	Гидравлик радиус-R,	Налуу, %	V, м/с	Q, м3/с
400 С		0.1652	1.2016	0.1375	5.0	1.345	0.2222

Дээрх тооцоог үндэслэн Геодези усны барилга байгууламжийн газартай зөвшилцөн борооны ус зайлуулах байгууламжийн өртөгийг багасгах, ашиглалтын явцад байгууламжийг цэвэрлэх, ашиглах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор замына 1 талд 400 С төрлийн бетон сувгийг 20м тутамд байршуулж усыг зайлуулахаар төсөллөсөн.

Дөрөв. Үерийн сувагт хийх ус зайлуулах хоолой

Одоо байгаа үерийн сувгийн хэмжээ 2.5х2.0м бөгөөд тус үерийн сувагтай уялдуулан ус зайлуулах 2.5х2.0м төмөрбетон дөрвөлжин хоолой төсөллөсөн.

Дүгнэлт:

1. Трасс-1 болон Трасс-2-т 20м тутамд байрлах 400 С төрлийн U бетон сувгуудын зарцуулга 0.56м^3/с, 0.34м^3/с тус тус байгаа нь тооцоот зарцуулгыг хангахаар байна.
2. Трасс-2-т төлөвлөж буй ус зайлуулах хоолойг одоо байгаа үерийн сувагтай уялдуулан ажлын зурагт заасны дагуу хийх шаардлагатай.
3. Ус зайлуулах U сувгийг хөвөө хэсэгт 4%-ийн налуутай байхаар, харин хажуу налуу хэсэгт замын гадаргуугийн дагуу үерийн сувагтай уялдуудан i≤0.3%-ийн налуутай байхаар төлөвлөсөн.



Зураг 7.1.1 Гадаргуун ус зайлуулах нэг маяг

БҮЛЭГ 6: ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Шинээр төсөллөж буй авто замын хөдөлгөөн зохион байгуулалтын төсөлөлтийг “MNS 4596-2014 – Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм”, “MNS 4597-2014 - Авто замын тэмдэг Техникийн шаардлага”, “MNS 4759-2013 Авто замын хэвтээ тэмдэглэгээ Техникийн шаардлага” тус тус стандартуудыг үндэслэн хийсэн.

Одоо байгаа нарны замын хөдөлгөөн зохион байгуулалттай уялдуулж уулзвартай хэсгийн төлөвлөлтийг хийсэн. Трасс – 2-ийн эхлэл хэсэг нь Нарны замаас төлөвлөж буй замруу орох цор ганц уулзвар юм. Тус зам нь нэг чигийн хөдөлгөөнтэй юм ба төгсгөл хэсэг нь Трасс-1-тэй холбогдоно. Трасс – 1-ийн хувьд 0+000.000 - 0+234.333 хүртэл 1 эгнээ 3.0м өргөнтэй, 0+260.298 - 0+509.772 хүртэл 2 эгнээ 6м өргөнтэй. Трасс – 2-ийн төгсгөл хэсэг нь трасс 1-ийн энэхүү эгнээ нэмэгдэх хэсэгтэй огтолцдог. Уг төлөвлөсөн уулзварын хөдөлгөөн зохион байгуулалт нь зохицуулдаггүй уулзвар учраас гол ба туслах замын уулзварт туслах замаас яваа жолооч гол замаас ирсэн тээврийн хэрэгсэлд зам тавьж өгөх бөгөөд дарааллын болон заах тэмдгээр хөдөлгөөн зохицуулагдах бөгөөд “МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРЭМ” хуулийн 15.8-15.12-д заасны дагуу байна.

Трасс-2-ын 0+230.000-д авто машин буцаж эргэх нөхцлийг бүрдүүлж U хэлбэрийн эргэлт төсөллөсөн бөгөөд “Авто зам төсөллөх” 22-004-2016 норм, дүрмийн бүлэг1 “Авто замын ангилал ба төсөллөлтийн үндсэн зарчим”-д заасан Хавсралт1, Хүснэгт 2 “Тооцоот тээврийн хэрэгслийн хамгийн бага эргэх радиус”-ын хотын доторх энгийн сургуулийн автобус машиныг сонгосон. Мөн “A police on Gemetric Design of Highway and Streets” норм дүрмийн Location and Design of U-turn median opening хэсэгт заасан шаардлагын дагуу авто замын мөрийг IndorCAD программаар шалгасан.

Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй зөвшилцөж хэвтээ тэмдэглэл, тэмдгийг төсөллөж хавсаргав.

БҮЛЭГ 7: ГАРЦ УУЛЗВАР

Гарц уулзварыг норм стандартын шаардлагыг хангахаар төлөвлөсөн.

БҮЛЭГ 8: ЗАМЫН ТОНОГЛОЛ

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын тэмдэг, тэмдэглэгээг хийхээр зураг төсөвт тусгав. Замд тавих тэмдэг нь “Замын тэмдэг” MNS 4597-2013, замын тэмдэглэгээ нь “Замын тэмдэглэл” MNS 4759-2014 стандартыг хангасан байна.

Явган замыг "Авто замын байгууламж, явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам" MNS 5682:2006, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төсөллөх заавар" MNS 6056:2009 стандартад заасны дагуу барина.

Хүснэгт 10.1 Замын тэмдэгний байршил

№	Байрлал	Тэмдэгний дугаар		Төрөл
		Зүүн	Баруун	
1	Трасс - 1	3.4		Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
2	Трасс - 1	4.1.б		Заах тэмдэг
				(Хөдөлгөөний чиглэл)
3	Трасс - 1	5.8		Мэдээлэх тэмдэг
				(Нэг чигийн хөдөлгөөн)
4	Трасс - 1	5.7		Мэдээлэх тэмдэг

				(Нэг чигийн хөдөлгөөн)
5	Трасс - 1	3.3.б		Дарааллын тэмдэг
				(Туслах зам нийлнэ)
6	Трасс - 1	5.19.б		Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
7	Трасс - 1	3.1		Дарааллын тэмдэг
				(Гол зам)
8	Трасс - 2		5.7	Мэдээлэх тэмдэг
				(Нэг чигийн хөдөлгөөн)
9	Трасс - 2	5.17		Мэдээлэх тэмдэг
				(Зогсоол)
10	Трасс - 2		3.3.б	Дарааллын тэмдэг
				(Туслах зам нийлнэ)
11	Трасс - 2		3.3.б	Дарааллын тэмдэг
				(Туслах зам нийлнэ)
12	Гарц - 1		5.19 а.б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
13	Гарц - 1		5.9.а	Мэдээлэх тэмдэг
				(Нэг талын замын хөдөлгөөнөөр явах)
14	Гарц - 1		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
15	Гарц - 2		5.19 а.б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
16	Гарц - 2		5.9	Мэдээлэх тэмдэг
				(Нэг талын замын хөдөлгөөнөөр явах)
17	Гарц - 2		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
18	Гарц - 3		5.19 а.б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
19	Гарц - 3		4.1.е	Заах тэмдэг
				(Хөдөлгөөний чиглэл)
20	Гарц - 3		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
21	Гарц - 4		5.19 а.б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
22	Гарц - 4		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
23	Гарц - 5		5.19 а.б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
24	Гарц - 5		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
25	Гарц - 6		5.19 а.б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)

26	Гарц - 6		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
27	Гарц - 7		5.19 а.б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
28	Гарц - 7		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
29	Гарц - 8		5.19 а.б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
30	Гарц - 8		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
31	Гарц - 9		5.19 а.б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
32	Гарц - 9		5.9	Мэдээлэх тэмдэг
				(Нэг талын замын хөдөлгөөнөөр явах)
33	Гарц - 9		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
34	Гарц - 10		5.19 а.б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
35	Гарц - 10		5.9	Мэдээлэх тэмдэг
				(Нэг талын замын хөдөлгөөнөөр явах)
36	Гарц - 10		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
37	Уулзвар 1-2	2.1		Хориглох тэмдэг
				(Орох хориотой)
38	Уулзвар 3-2	2.1		Хориглох тэмдэг
				(Орох хориотой)
39	Уулзвар 3-2	4.2.а		Заах тэмдэг
				(Саадыг баруун гар талаар тойрч гарна)
40	Уулзвар 3-1		5.8	Мэдээлэх тэмдэг
				(Нэг чигийн хөдөлгөөн)
41	Уулзвар 3-1		3.4	Дарааллын тэмдэг
				(Зам тавьж өгнө)
42	Уулзвар 3-1		5.19 а	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)
43	Уулзвар 2-2		5.19 б	Мэдээлэх тэмдэг
				(Явган хүний гарц)

Хүснэгт 10.2 Замын тэмдэглэгээний төрөл ба байршил

Тэмдэглэгээний дугаар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1.1	м2	17.47	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эсрэг урсгалын тусгаарлах
1.5	м2	9.77	Эгнээний хилийг тэмдэглэх
1.7	м2	0.30	Уулзвар дээрх хөдөлгөөний эгнээг тэмдэглэх
1.11	м2	12.63	Зогс шугам тэмдэглэл
1.13а	м2	136.47	Явган хүний гарц тэмдэглэл
1.15.а	м2	2.32	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарласан арлыг тэмдэглэх
1.17	м2	18.39	Чиг заагч сум
1.12	м2	0.70	Зам тавьж өгнө
	Нийт	**198**	

Хүснэгт 10.3 Замын тэмдэг болон тэдгээрийн тоо ширхэг

Хориглох тэмдэг		
Дугаар	**Тоо хэмжээ**	**Зураг**
2.1	2	
Дарааллын тэмдэг		
3.1	1	

3.4	12	
3.3.б	3	
Заах тэмдэг		
4.1.е	1	
4.1.б	1	
4.2.а	1	
Мэдээлэх тэмдэг		
Дугаар	**Тоо хэмжээ**	**Зураг**

5.19.а.б	23	
5.17	1	
5.7	2	
5.8	2	
5.9	4	
Нийт	**53 ширхэг**	

БҮЛЭГ 9: ТӨМӨР ХАЙСНЫ ОНЦЛОХ ТЕКНИКИЙН ШААРДЛАГА

9.1 Төмөр хайс тавих

Замын тодорхой хэсгүүдэд төмөр хашлагыг зурагт үзүүлсний дагуу тавина. Төмөр хайсны шонгийн сууринд B15 ангийн бетон хэрэглэнэ. Манаасны бетон, бэхжилтээ бүрэн авсны дараа арын шороон дүүргэлтийг хийж ТИ-ийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл нягтруулна. Төмөр хайсыг үйлдвэрлэгчээс гаргасан зураг, зааврын дагуу, эсвэл ТИ-ийн зааварчилгаагаар угсарч суурьлуулна. Гүйцэтгэгч нь тохиромжтой тоног төхөөрөмжийг ашиглан хайсны шонг тогтоосон зай, өндөр болон чигийг нарийн баримтлан суурьлуулах ба улмаар хайсыг зохих аргачлалын дагуу шонд бэхэлнэ. Хэрэв шонг нүх ухаж суулгасан бол нүхийг буцааж булан сайтар чигжих буюу цутгаж, илүүдэл материалыг зайлуулна. Төмөр хайс угсрах үед гэмтсэн зэврэлтээс хамгаалах будгийг сэргээн будна. Төмөр хайсыг угсарч дуусаад ТИ-ээр батлуулсны дараа гайкуудыг хөдөлгөөнгүй болгох зорилгоор боолтод буюу төмөр хайсны төмөрт гагнаж өгнө.

9.2 Түүхий эд, материалд тавигдах шаардлага

Хайсны бүтээцийг үйлдвэрлэхэд хэрэглэх материалыг зураг төсөлд заасан байна.

Төмөр хайсны хийцүүдийн материалын болон бусад холбогдох шаардлагууд нь MNS 5614:2016 стандартын шаардлагад бүрэн нийцсэн байх ба ТИ-ийн зөвшөөрсөн үйлдвэрлэгчээс авна.

Зэврэлтээс хамгаалах будгийг тусгай зориулалтын нунтагаар буюу AASHTO M300-03 (2007)-ын шаардлагыг хангасан сайн чанарын органик бус, цайраар баялаг будгаар будна.

Хайсыг замын тэнхлэгээс тогтоосон зай буюу түвшинд ±20мм-ийн нарийвчлалтайгаар угсарна. Зэрэгцээ залгагдах нуруу төмрийн хоорондох хэвтээ ба босоо түвшин 5мм-ээс илүүгээр зөрж болохгүй. Хүлцэх алдаанаас илүү гарсан тахир муруй буюу өндөр нам тавигдсан хэсгийг дахин засварлаж хэвийн болгох ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийнэ.

9.3 Хүлцэх алдаа

Төмөр хайсны хоорондын зай зурагт зааснаас ±2мм-ээс илүү байж болохгүй. Зэрэгцээ тавигдсан хоёр хайсны нүүрэн талын гадаргуу болон дээд талд хэмжсэн төвшин нь 1мм-ээс илүү зөрүүтэй байж болохгүй. Хүснэгт 9.3.1. Төмөр хайсны материалын түүвэр

2м урт хаалтын материалын түүвэр					
№	Марк	Нэр	Тоо ширхэг, ш	Нэгж жин, кг	Нийт жин, кг
1	ГОСТ 10704-91	Труба 60х60х2 L=1500	1	5.40	5.40
2	ГОСТ 10704-91	Труба 60х30х2 L=1940	2	5.42	10.84
3	ГОСТ 10704-91	Труба 30х20х1.5 L=870	2	1.10	2.20
4	ГОСТ 10704-91	Труба 20х20х1.5 L=870	1	0.74	0.74
5	ГОСТ 10704-91	Труба 20х20х1.5 L=1880	1	1.58	1.58
6	ГОСТ 10704-91	Труба 20х20х1.5 L=1200	2	1.00	2.00
6.1	ГОСТ 10704-91	Труба 20х20х1.5 L=590	4	0.5	2.00
7	ГОСТ 19903-74	ф60х2	4	0.02	0.06
8	ГОСТ 22036-76	Шпилька М8х140	2		
9	ГОСТ 5915-70	Гайка М8	4		
10	ГОСТ 11371-78	Шайба 8	4		
Нийт					24.82

БҮЛЭГ 9: АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ

10.1 Танилцуулга

Төслийн обьект нь Баянзүрх дүүргийн 13-р хороонд байрлалтай. Авто замын уур амьсгалын IIB Уулын засвар хоорондын тал хээрийн дэд бүс бүсэд хамрагдана.

Төслийн зам нь карьер, асфальбетон үйлдвэрлэлийн бүсээс 15.3км орчим зайд учраас материал тээвэрлэлтийн зардал өндөр байна.

10.2 Барилгын бэлтгэл ажил

Барилгын бэлтгэл ажилд Гүйцэтгэгчийг сонгох, хяналт тавих хяналтын инженерүүдийг сонгох, байрлуулах, нүүлгэн шилжүүлэх, кемп байгуулах, улаан шугам хүлээн авч гадаслагаа хийх, нэмэлт репер байгуулах, ул хөрс карьераас дээж авч лабораторид шаардлагатай шинжилгээ хийх, цахилгаан хангамж, инженерийн бусад байгууламжийг буулгах, шилжүүлэх, хамгаалах гэх мэт ажлууд орох ба үүгээр хязгаарлагдахгүй.

Монгол орны хүйтний улирлын хугацаа урт тул барилгын ажлыг богино хугацаанд гүйцэтгэх шаардлагатай болно. Барилгын ажлыг 2022 оны 4-р сараас 11-р хүртэлх хугацаанд гүйцэтгэж, ашиглалтад орохоор тооцож болно. Үүний тулд дараах төлөвлөгөөг зөвлөмж болгов.

№	Ажлуудын нэрс	Хугацаа
1.	Замын ажлын зураг төслийг боловсруулж, улсын магадлан хийлгэж баталгаажуулах	2021 оны 09сар – 2022оны 02-р сар
2.	Барилгын ажилд хяналт тавих Мэргэжлийн инженерийг томилох	2022 оны 4-р сар
3.	Гүйцэтгэгчийг сонгох, гэрээ байгуулах	2022 оны 4-р сар
4.	Гүйцэтгэгчийн машин техник, нүүлгэн шилжүүлэлт хийх	2022 оны 4-р сар
5.	Лаборатори байгуулах, ажилд хэрэглэх материалуудын шинжилгээг хийж эхлэх	2022 оны 4-р сар
6.	Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг МХЕГ-аас авах	2022 оны 4-р сар
7.	Замын геодезийн хэмжилтийг хийж, гадаслагаа хийж эхлэх	2022 оны 4-р сар
8.	Талбайд инженерийн барилга байгууламжийг буулгах шилжүүлэх,	2022 оны 5-р сар
9.	Газар шорооны ажил эхлэх, хөрс хуулах	2022 оны 5-р сар

Дулааны улирал богино учир бэлтгэл ажлуудыг аль болох эрт хийх нь зүйтэй.

10.3 Төслийн хэрэгжилт буюу зам барилгын ажил

Төсөл 2022 онд бүрэн хэрэгжиж дуусна гэж үзнэ. Төслийг хэрэгжүүлэх явцад дараах асуудлыг онцгой анхаарах хэрэгтэй.

1. Гэр хорооллын бүс нутагт барилгын ажил явагдах тул тээврийн хөдөлгөөний нөхцлийг онцгой анхаарах хэрэгтэй.
2. Инженерийн байгууламж буулгах, шилжүүлэх, тэдгээртэй ойр ажиллах үед анхаарал болгоомжтой ажиллах, шаардлагатай бол холбогдох мэргэжилийн хүмүүсийг байлцуулах, тэдний заавар зөвлөмж, Технкийн нөхцөлд заасны дагуу ажиллах хэрэгтэй. Инженерийн байгууламжийг өргөх, буулгах, шилжүүлэх зэрэг ажлыг заавал Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.
3. Газар чөлөөлөлтийн асуудлыг Захиалагч байгууллага онцгой анхаарах хэрэгтэй.
4. Төслийн барилгын ажил нь харьцангуй бага талбайд хийгдэх боловч туршлагатай, буталсан чулуун суурь, асфальтобетон хучилт барьж байсан туршлагатай, өөрийн лабораторитой, инженер, техникийн туршлагатай баг бүрдүүлсэн, урьд нь ажил гүйцэтгэх явцдаа алдаа дутагдал гаргаж байгаагүй Гүйцэтгэгч сонгон шалгаруулах нь зүйтэй.
5. Зам барилгын ажилд хэсэгт тус бүр дээр 1 ерөнхий гүйцэтгэгч, дотроо 2-ээс илүүгүй

туслан гүйцэтгэгчтэй байж болно.

6. Барилгын ажилд хяналт тавих инженерүүд нь замын болон материалын, геодезийн туршлагатай инженерүүдээс бүрдсэн баг ажиллана. Барилгын ажилд гарсан зураг төсөлтэй холбоотой асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэх үүднээс зураг төсөл Зохиогчидтой нягт хамтран ажиллабал илүү үр дүнтэй байна.
7. Барилгын үргэлжлэх хугацаа 2022 оны 4-р сараас 2022 оны 11-р сарын хооронд байна.
8. Карьер ашиглах болон төв замаар тээвэр хийх зөвшөөрлийг Захиалагч байгууллага нь орон нутгийн захиргаанаас авч, ажил саадгүй явуулах нөхцлийг бүрдүүлнэ.
9. Бетоны ажилд хүйтнээс хамгаалах болон арчлалтын арга хэмжээ авах шаардлагатай болно.
10. Барилгын ажлыг саадгүй, шуурхай хийхийн тулд талбайн лабораторид шинэлэг багаж ашиглах нь зүйтэй.
11. Ажлын явц нь гүйцэтгэгчийн санхүүгийн нөөцтэй шууд холбоотой учир урьдчилгаа санхүүжилт хангалттай тооцох, гүйцэтгэгчийг санхүүжилт болон материалаар саатуулахгүй байхыг Захиалагч анхаарах нь чухал.
12. Гүйцэтгэгч барилгын ажлын графикийг сар, 7 хоногоор гаргаж, чанд мөрдөж ажиллана.

Зам барилгын ажлыг цаг хугацаанд дуусгахад нөлөөлөх хүчин зүйлүүд:

1. Захиалагч нь газар олгох болон ажил эхлүүлэх зөвшөөрөл, бусад инженерийн байгууламжтай холбоотой Техникийн нөхцөл авахад дэмжлэг үзүүлэх
2. Орон нутгийн захиргааны зүгээс замын барилгын ажилд дэмжлэг үзүүлэх, карьер, шороон орд тогтоох, зөвшөөрөл өгөх гэх мэт ажилд аль болох цаг хугацаа алдалгүй арга хэмжээ авах
3. Газар чөлөөлөлт хийж, барилгын ажил саадгүй явагдах нөхцлийг бүрдүүлэх
4. Чанарын хяналтыг туршлагатай инженерээр хийлгэх
5. Гүйцэтгэгч нар нь барилгын ажилд бүтээлч, санаачлагатай хандаж, өндөр бүтээлтэй машин механизм, тоног төхөөрөмж ашиглах
6. Ажлуудын уялдаа холбоо, цаг хугацаа, машин механизм, хүн хүчний нөөц бололцоо зэргийг сайтар төлөвлөж ажиллах
7. Гүйцэтгэгч ажлын доголдол гаргах, ажлаа төлөвлөсөн хугацаандаа хийж чадахгүй нь тодорхой болсон нөхцөлд нэмэлт туслан гүйцэтгэгч оруулах, өөр чадвартай гүйцэтгэгчид шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах

10.4 Барилгын ажлын төлөвлөгөө

Барилгын ажлын тоо хэмжээ, ажил гүйцэтгэх хугацаатай уялдуулан гүйцэтгэгч нь ажлын төлөвлөгөө боловсруулж, Хяналтын инженер, Захиалагчаар батлуулна. Ажлын төлөвлөгөөнд дараах зүйлүүд тусгагдсан байх ба үүгээр хязгаарлагдахгүй.

1. Ажил бүрийн гүйцэтгэх хугацааг сар, долоо хоног, өдрөөр нарийвчлан тооцох. /материал бэлтгэл, лабораторийн шинжилгээ, ГША, хучлага, тоноглолын ажил гэх мэт/
2. Ажлын тоо хэмжээ, ажил гүйцэтгэх хугацааг үндэслэн шаардлагатай хүчин чадал бүхий машин механизм, тоног төхөөрөмжийн тооцоо, хүн хүч, мэргэжилтний хангалтын байдлыг тооцох
3. Материал бэлтгэл, хангамжийн тооцоог хийх
4. Бэлтгэл ажил, нүүлгэн шилжүүлэлт, геодезийн дурандлага, гадаслагаа
5. Ажил бүрийн уялдаа холбоог харуулсан график, төлөвлөгөө

БҮЛЭГ 11: ЗАСВАР АРЧЛАЛТ

11.1 Ерөнхий

Авто замыг жилийн бүхий л хугацааны туршид засвар арчлалт хийж, тээврийн хөдөлгөөнийг тав тухтай, аюулгүй нэвтрүүлэх нөхцлийг хангана. Тухайлбал: өвлийн нөхцөлд зам дээр тогтсон цас, мөсийг цэвэрлэх, дулааны улиралд талбай дээр тогтсон хог шороо, ус зайлуулах байгууламжийг цэвэрлэх гэх мэт ажлуудыг байнга хийх шаардлагатай. Өвлийн улиралд халтиргаа гулгаанаас хамгаалах зорилгоор шинж чанар нь тодорхойгүй химийн идэмхий чанартай бодис хэрэглэж болохгүй.

Хучилтын засварыг засвар арчлалтын технологийн дагуу хийнэ. Түүнчлэн тэмдэглэгээ, тэмдэг, бусад байгууламжийг засварлах, сэргээх, шинэчлэх ажлуудыг хийнэ.

Тээврийн хөдөлгөөний үзэгдэх орчныг хязгаарласан хаалт, саад, мод бут зэргийг буулгаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.

11.2 Асфальтобетон хучилттай замын засвар арчлалт

А. Хагарал нөхөх

Хучилтанд температур болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үйлчлэлээс хагарал, эвдрэл бий болно. Асфальтобетон хучилтанд 1-3мм-ийн өргөн хялгасан хагарал үүссэн тохиолдолд түүнийг даралттай хийгээр үлээлгэж цэвэрлэн битум, битумын мастик шахаж бөглөнө. Хэрвээ 3мм-ээс илүү өргөн хагарал үүссэн бол түүнийг тодорхой өргөнд ухаж зайлуулан, элсэн асфальт хольцоор дүүргэж нягтруулна.

Б. Нөхөөс хийх

Хучилтанд үүссэн торон хагарал, пучин, цөмрөлт зэргийг тодорхой судалгааны үндсэн дээр засварлана. Тухайлбал, үүссэн эвдрэл ус зайлуулалт муугаас уу, сууриас уу эсвэл асфальтбетон хучилтын шинж чанараас болж үүссэн эсэхийг заавал тогтоож, үүний үндсэн дээр засварын аргачлалаа сонгоно.

Хэрвээ ус зайлуулалт хангалтгүйгээс болж эвдрэл үүсч байгаа бол ус зайлуулалтыг сайжруулах арга хэмжээг авах ба ус зайлуулах байгууламжийг хэвийн ажиллагаатай болгох хэрэгтэй.

Хэрвээ сууриин байдал муудсанаас болж эвдрэл үүссэн бол тухайн хэсгийг суурь хучилтаар нь хуулж зайлуулан шинээр суурь, хучилт хийж нягтруулах шаардлагай. Энэ үед geograde, geotextile ашиглавал илүү үр дүнтэй.

Сууриас болж эвдрэл үүсээгүй бол хучилтыг геометр хэмжээтэй зүсэж, хуулж зайлуулан, битум түрхлэг хийж, асфальто хольцоор нөхөөс хийнэ.

11.3 Ус зайлуулах байгууламжийн засвар

Барилгын ажлын явцад болон дууссанаас хойш гадаргуугийн ус зайлуултыг хангалттай байлгах арга хэмжээг байнга хийнэ. Ус өнгөрүүлэх хоолой, далд шуудуу хог шороо, цас мөсөнд дарагдаж бөглөрөх, ажиллагаагүй болохоос сэргийлэх арга хэмжээ авахаас гадна, ус нэвчихээс сэргийлэх, эвдрэл гэмтэл гарсан бол цаг тухайд нь засна. Зам дээр ус тогтох, ус нэвчихээс сэргийлж хагарал гарсан даруйд битумын мастикаар бөглөж, тунасан, суулт үүссэн газруудыг засварлах арга хэмжээ авна.

БҮЛЭГ 12: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Барилгын ажил дээр ажиллаж буй бүх ажилчид, ИТА нар нь МУ-ын ХАБЭА-н тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, байгууллагын дотоод журам болон эдгээртэй холбогдон гарсан тушаал, шийдвэр, захирамжийг дагаж мөрдөх үүрэгтэй. Барилгын үйл ажиллагаа явуулж буй байгууллага нь дараах ажлуудыг хийх ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

1. ХАБЭА-н асуудал хариуцсан зөвлөл /орон тооны бус/ байгуулах
2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс /орон тооны бус/ байгуулах
3. ХАБЭА-н асуудал хариуцсан инженерийг томилох
4. ХАБЭА-н тухай хуулийн дагуу ажилчид, ИТА нарыг ажлын тусгай хувцас, хэрэгслээр хангах
5. Ажилчид, ИТА нарт ХАБЭА-н сургалт зохион байгуулах
6. Гал унтраах тоноглол ашиглах, анхны тусламж үзүүлэх, чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах
7. Улс, нийслэл, аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагаар хяналт, шалгалт хийлгүүлэх, тэдний гаргасан дүгнэлтийн дагуу арга хэмжээг авах
8. ХАБЭА-н талаар хийсэн ажлын мэдээг тайлагнах, бүртгэх
9. Бүх ажилтанд ХАБЭА-н ажиллагааны зааварчилгаа өгч, гарын үсэг зурж баталгаажуулах
10. Машин механизмын техникийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг ажилчид, ИТА нарт танилцуулах
11. Зам барилгын ажлын аюулгүйн техникийн дүрэм, зааварчилгааг мөрдөж ажиллах
12. ХАБЭА-н үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллах
13. ХАБЭА-н тухай хууль, журмыг зөрчсөнөөс үүдэн гарах бүх хариуцлагыг хүлээх

БҮЛЭГ 13: ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Зөвлөх нь инженерийн байгууламжтай холбоотой Техникийн нөхцлийг холбогдох байгууллагуудаас авч, зөвшөөрөлцлөөр баталгаажуулсан.

<u>Нийслэлийн авто замын хөгжлийн газар:</u>

Нийслэлийн зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Одсүрэнгийн баталсан “Авто замын зураг төсөл боловсруулах даалгавар”, Нийслэлийн авто замын хөгжлийн газартай зөвшилцсөн дэвсгэр зургийг хавсаргав.

<u>Нийслэлийн газар зохион байгуулалтын алба:</u>

Тус байгууллагаас зөвшилцөн зураг төсөлд баталгаажуулалт хийсэн ба авто замын трассад 19 нэгж талбар өртсөн гэсэн хариу өгсөн. Авто замын трассад өртсөн обьект, нэгж талбарыг хавсралт.4-д үзүүлэв.

<u>Ус сувгийн удирдах газар:</u>

1. Трассад орсон бохир усны худгийг бетон хийцээр өндөрлөж тааруулах.
2. Зориулалтын даацын люк таг тавих

Трассыг төлөвлөхдөө эдгээр ажлуудыг үндэслэн дагуу огтлолыг төлөвлөсөн ба төсөвт тооцсон.

<u>“Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨК:</u>

1. Замын трассад орсон худгийн таг хүзүүг тааруулж хүчитгэн шинээр суурилуулна.
2. Замын трассад орсон агаарын баганыг замын трассын гадна шилжүүлэн суурьшуулж

кабелыг шинээр татна.

3. Сувагчлалыг гэмтээхгүй хамгаалах арга хэмжээ авч газар шорооны ажлыг гараар гүйцэтгэнэ.

Ажилбаруудын зардлыг тооцож нийт төсөвтд суулгасан болно.

Цахилгааны шугам:

Гэрэлтүүлэг суулгах, цахилгааны шон шилжүүлэх ажлын зураг, төсвийг "ЭЛСТА" ХХК боловсруулж, төсөвт тооцсон.

